



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 99125777
цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.3 Нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ЦЭРЭНЛХАМ ТАНАА

2022.02.24 № 02/50
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Илүү цагаар ажилласан багш ажилчдын илүү цагийн нэмэгдлийг олгохдоо Засгийн газраас баталсан журмын хавсралт хүснэгтийн дагуу Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас бөглөөгүйгээс зарим багш ажилчид илүү цагаар ажилласан нь тогтоогдохгүй, 2022 оны эцэст 0.6 сая төгрөгийн өр төлбөртэй байгаа нь НДШ өр бөгөөд цалингийн программын кодын залруулгатай холбоотой үүссэн өр байна. Санко маркетинг монголиа ХХК-иас ухаалаг дэлгэцийг хүлээн авч 13.0 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны яамнаас 75.1 сая төгрөгийн компьютер, таблет сургалтын хэрэглэгдэхүүн, Данагруп, Хөшөөт хөгжил сангаас 3.5 сая төгрөгөөр орос хэлний кабинет тохижуулсныг хандиваар, төсвөөс 0.3 сая төгрөгийн ном худалдан авч Боловсрол соёл урлагийн газраас 5.4 сая төгрөгийн сурах бичиг үнэгүй авсан, Тогтвортой хөгжил 2 төслийн 3.9 сая төгрөгөөр алаг хавтан авч зам хийж нийтийн эзэмшилд бүртгэсэн, Урсгал засварт 2.5, төсвөөс 12.9 сая төгрөгөөр 7 нэр төрлийн 49 ширхэг тавилга эд хогшил худалдан авч бүртгэсэн байна. Боловсролын мэдээллийн технологийн төвөөс 1.5 сая төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж, 88.7 сая төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, батлагдсан төсвийг 9.5 сая төгрөгийг хэмнэжээ.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль 2021-2022 оны хичээлийн жилд 90 багш, ажилчин, 36 бүлэгт 1030 сурагчидтайгаар сургалтынхаа үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс багын 17 бүлэгт 513 сурагч, дундын 21 бүлэгт 517 сурагч суралцаж байгаа бөгөөд урлаг спорт, хичээлийн 14 секц дугуйланд бүх хүүхдийн 60% нь хамрагддаг. 2022 онд 4 зорилт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 21 бүлэгт нийт 78500 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 106.7 сая төгрөгийг зарцуулжээ.

2021-2022 оны хичээлийн жилд “Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц” гэсэн БШУЯ-ы зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж “Хүүхдийн хөгжил багшаас шалтгаална” гэсэн уриа дэвшүүлэн ажилласан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангил эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,649,862.0</u>	<u>124,495,375.0</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	9,512,330.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	9,512,330.0
3121	Төгрөг	-	9,512,330.0
31211	Төрийн сангийн харилцах	-	9,512,330.0
33	АВЛАГА	13,657,705.9	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	657,705.9	-
335	Бусад авлага	13,000,000.0	-
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	100,992,156.1	114,983,045.0
351	Түүхий эд материал	5,030,610.0	2,923,610.0
35130	Эм боох материал	5,030,610.0	2,923,610.0
354	Хангамжийн материал	95,961,546.1	112,059,435.0
35410	Бичиг хэргийн материал	128,000.0	3,442,500.0
35420	Аж ахуйн материал	68,418,508.1	78,864,617.1
35430	Сэлбэг хэрэгсэл	677,500.0	1,987,000.0
35440	Түлш, шатах тослох материал	13,873,720.0	13,873,720.0
35470	Бусад хангамжийн материал	12,863,818.0	13,891,598.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,910,446,425.2</u>	<u>2,889,193,615.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,910,446,425.2	2,889,193,615.9
392	Биет хөрөнгө	2,515,706,425.2	2,494,453,615.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,674,208,547.3	2,678,180,547.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(270,993,758.8)	(360,307,154.1)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	256,447,090.6	335,143,860.6
39206	Хуримтлагдсан элэгдэл	(237,744,085.7)	(250,089,848.9)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,301,191.7	176,207,191.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(108,004,110.3)	(128,876,767.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,491,550.5	44,195,786.5
393	Биет бус хөрөнгө	394,740,000.0	394,740,000.0
39301	Програм хангамж	2,409,948.0	2,409,948.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,409,948.0)	(2,409,948.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	394,740,000.0	394,740,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,025,096,287.2</u>	<u>3,013,688,990.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>102,988.0</u>	<u>625,408.8</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	102,988.0	625,408.8
413	Өглөг	102,988.0	625,408.8
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	102,988.0	625,408.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,024,993,299.2</u>	<u>3,013,063,582.1</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,024,993,299.2	3,013,063,582.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,181,249,010.0	1,181,249,010.0

51101	Өмч: - төрийн	1,181,249,010.0	1,181,249,010.0
512	Хуримтлагдсан үр дүн	45,972,374.9	34,042,657.8
51210	Өмнөх үеийн үр дүн	45,972,374.9	45,972,374.9
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,929,717.1)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,797,771,914.3	1,797,771,914.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,025,096,287.2	3,013,688,990.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,816,462,622.9	2,043,397,690.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,215,646.9	22,238,090.0
120	Нийтлэг татварын бус орлого	17,215,646.9	16,833,854.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,215,646.9	11,690,354.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,615,646.9	11,690,354.0
120005	Түрээсийн орлого	-	790,000.0
120009	Бусад орлого	-	4,353,500.0
122	Тусламжийн орлого	-	5,404,236.0
122001	Хандив тусламж /дотоод/	-	5,404,236.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,799,246,976.0	2,021,159,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,424,451,200.0	1,707,145,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,707,145,100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,398,561,800.0	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	25,889,400.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,342,276.0	14,845,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,142,276.0	14,845,100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	316,453,500.0	299,169,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,252,600.0	299,169,400.0
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	116,200,900.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,748,223,155.1	2,055,327,407.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,748,223,155.1	2,055,327,407.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,688,556,573.4	2,015,310,407.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,174,865,999.2	1,361,034,863.0
210101	Үндсэн цалин	759,109,799.3	968,193,616.0
210102	Нэмэгдэл	351,625,499.9	334,293,947.0
210104	Урамшуулал	64,130,700.0	58,547,300.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,152,700.0	167,478,803.7
210201	Тэтгэврийн даатгал	111,082,700.0	115,047,046.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,888,900.0	13,534,946.6

210203	ҮОМШӨ-ний даатгал	9,381,600.0	10,827,957.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,345,400.0	2,551,714.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,454,100.0	25,517,139.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,375,335.0	244,156,800.0
210301	Гэрэл, цахилгаан	3,196,113.0	5,362,300.0
210302	Түлш, халаалт	174,537,700.0	204,336,000.0
210303	Цэвэр, бохир ус	24,641,522.0	34,458,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,905,972.0	836,000.0
210401	Бичиг хэрэг	3,271,750.0	316,000.0
210402	Тээвэр, шатахуун	90,700.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,010,085.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	428,200.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,700.0	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,425,987.0	520,000.0
210408	Бараа материал акталсны зардал	6,153,550.0	-
2105	Нормативт зардал	6,792,127.0	68,395,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,669,627.0	1,675,000.0
210502	Хоол, хүнс	-	66,720,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,122,500.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,094,800.0	-
210604	Урсгал засвар	13,094,800.0	-
2107	Томилолт, зочны зардал	160,000.0	-
210702	Дотоод албан томилолт	160,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.0	6,247,780.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,247,780.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,201,640.1	167,161,160.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	480,100.0	30,817,245.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,304,438.0	15,073,600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,417,102.1	121,270,315.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,666,581.8	40,017,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,466,678.0	40,017,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,475,500.0	40,017,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,991,178.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	199,903.8	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	199,903.8	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>68,239,467.7</u>	<u>(11,929,717.1)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>68,239,467.7</u>	<u>(11,929,717.1)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,799,846,976.0</u>	<u>2,026,663,100.0</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>600,000.0</u>	<u>5,143,500.0</u>

120	Нийтлэг татварын бус орлого	600,000.0	5,143,500.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.0	4,353,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.0	4,353,500.0
120005	Түрээсийн орлого	-	790,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,799,246,976.0	2,021,519,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,424,451,200.0	1,707,145,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,707,145,100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,398,561,800.0	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	25,889,400.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,342,276.0	15,205,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,142,276.0	15,205,100.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	316,453,500.0	299,169,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,252,600.0	299,169,400.0
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	116,200,900.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,657,556,676.0	2,017,150,770.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,657,556,676.0	2,017,150,770.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,597,557,594.2	1,910,413,770.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,174,865,999.2	1,357,437,140.0
210101	Үндсэн цалин	759,109,799.3	995,074,474.8
210102	Нэмэгдэл	351,625,499.9	299,801,771.2
210104	Урамшуулал	64,130,700.0	62,560,894.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,152,700.0	169,856,200.0
210201	Тэтгэврийн даатгал	111,082,700.0	115,836,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,888,900.0	13,346,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,381,600.0	10,962,600.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,345,400.0	2,701,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,454,100.0	27,009,500.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,789,522.0	244,156,800.0
210301	Гэрэл, цахилгаан	3,610,300.0	5,362,300.0
210302	Түлш, халаалт	174,537,700.0	204,336,000.0
210303	Цэвэр, бохир ус	24,641,522.0	34,458,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,835,873.0	-
210401	Бичиг хэрэг	1,245,698.0	-
210402	Тээвэр, шатахуун	172,600.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	466,675.0	-
210404	Ном, хэвлэл	306,800.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,587,400.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,056,700.0	-
2105	Нормативт зардал	5,197,000.0	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,518,000.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,679,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,745,700.0	2,553,100.0

210604	Урсгал засвар	14,745,700.0	2,553,100.0
2107	Томилолт, зочны зардал	160,000.0	-
210702	Дотоод албан томилолт	160,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,008,000.0	14,306,770.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.0	4,318,500.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	-
210606	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,988,270.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,802,800.0	122,103,760.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.0	94,165,460.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,802,800.0	27,938,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,999,081.8	106,737,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,799,178.0	106,737,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,808,000.0	106,737,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,991,178.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	199,903.8	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	199,903.8	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	142,290,300.0	9,512,330.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	142,290,300.0	9,512,330.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,512,330.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,249,010.0	1,797,771,914.3	149,111,949.7	2,128,132,873.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,249,010.0	1,797,771,914.3	149,111,949.7	2,128,132,873.9
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(29,088,742.5)	(29,088,742.5)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,249,010.0	1,797,771,914.3	120,023,207.2	2,099,044,131.4
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,249,010.0	1,797,771,914.3	120,023,207.2	2,099,044,131.4
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,181,249,010.0	1,797,771,914.3	45,972,374.9	3,024,993,299.2
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,362,498,020.0	3,595,543,828.5	165,995,582.1	5,124,037,430.6
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,929,717.1)	(11,929,717.1)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,362,498,020.0	3,595,543,828.5	154,065,865.0	5,112,107,713.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,717,268,700.0	1,707,981,370.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,268,700.0	1,707,981,370.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,603,873,700.0	1,601,244,370.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,303,852,300.0	1,303,852,300.0
210101	Үндсэн цалин	1,019,114,700.0	910,235,597.8
210102	Нэмэгдэл	263,190,900.0	334,765,335.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,546,700.0	58,851,367.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,981,500.0	162,981,500.0
210201	Тэтгэврийн даатгал	110,827,500.0	110,827,500.0
210202	Тэтгэмжийн даатгал	13,038,500.0	13,038,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,430,800.0	10,430,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,607,700.0	2,607,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	26,077,000.0	26,077,000.0
2105	Нормативт зардал	165,400.0	-
210502	Хоол, хүнс	165,400.0	
2106	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,277,300.0	14,306,610.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,318,500.0	4,318,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,958,800.0	9,988,310.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,597,200.0	120,103,760.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,658,900.0	102,165,460.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,938,300.0	17,938,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,395,000.0	106,737,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,395,000.0	106,737,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	113,395,000.0	106,737,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,717,268,700.0	1,717,493,700.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,707,145,100.0	1,707,145,100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,707,145,100.0	1,707,145,100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,123,600.0	10,348,600.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,318,500.0	4,318,500.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,805,100.0	6,030,100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,512,330.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургууль нь хүүхэд бүрийн тасралтгүй хөгжлийн төлөө манлайлагч байж, өв тэгш хүмүүжилтэй, амьдрах чадвартай зөв хүүхдийг төлөвшүүлэхийг эрхэм зорилго болгон ажиллаж ирсэн байна. Сургуулийн хөгжлийг үе шаттай уялдуулан эрхэм зорилгыг шинэчилж хэт үнэлэх боломжтой цаг хугацаатай, хэмжигдэхүйц байхаар томьёолж түүнд хүрэх зорилтуудыг сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллажээ.

Тус сургууль 2021-2022 оны хичээлийн жилд 90 багш, ажилчин, 38 бүлэгт 1030 сурагчидтайгаар сургалтынхаа үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс багын 17 бүлэгт 513 сурагч, дундын 21 бүлэгт 517 сурагч суралцаж байгаа бөгөөд урлаг спорт, хичээлийн 14 секц дугуйланд бүх хүүхдийн 60% нь хамрагддаг. Одоо ажиллаж байгаа багш нараас АБТ ажилтан 42, арга зүйч багш 24, тэргүүлэх зэрэгтэй багш 34, зөвлөх зэрэгтэй 3, магистр багш 21, нийт багш нарын 81% нь зэрэгтэй болж багшлах боловсон хүчний чанар сайжирсан байна.

2021-2022 оны хичээлийн жилд “Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц” гэсэн БШУЯ-ы зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж “ Хүүхдийн хөгжил багшаас шалтгаална” гэсэн уриа дэвшүүлэн ажилласан.

Сургах, сурагцах үйлдлийн чухал нь сургахад бус харин сурагцах үйлдлийг суралцагчидтайгаа хамтран явуулж “Багш,суралцагч хоёр хичээл рүү хамтдаа” гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд ингэсэн нөхцөлд багшийн тасралтгүй суралцах хэрэгцээ үүснэ гэдгийг хүлээн зөвшөөрч хамтран ажиллахыг гол зорилгоо болгосон байна.

Бага боловсролын 40 хичээлийн 259 агуулгын 764 сурагцагчийн зорилгыг танхимаар 1518, теле хичээлээр 638, цахим хэлбэрээр 218, бие даан ажиллуулахаар 545 судлуулж, судлаагүй 140 үлдсэн байна. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин 95 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим

хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын дэргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын 2 дугаар сургуулийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны А/83 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлын зохион байгуулах ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна. Тооллогоор хуучирч гэмтсэн хугацаа нь дууссан шаардлага хангахгүй бараа материал байгааг ялгаж эд хариуцагч нараас хураан авч дараа онд актлуулахаар складанд шилжүүлж үлдээсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 2 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11.4 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	9,512.3	9,512.3
Авлага	13,657.7	0.0	-13,657.7
Бараа материал	100,992.1	114,963.0	13,990.9
Үндсэн хөрөнгө	2,910,446.4	2,889,193.6	-21,252.8
Нийт хөрөнгө	3,025,096.2	3,013,688.9	-11,407.3
Өр төлбөр	102.9	625.4	522.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,024,993.3	3,013,063.6	11,929.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,025,096.3	3,013,688.9	11,407.3

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- 2021 оны эцэст 13.6 сая төгрөгийн авлагатай байсан. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр, “Ховд аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу ерөнхий боловсролын сургуулиудад сүүлийн үеийн цахим технологи ашиглан сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Санко маркетинг монголиа ХХК-иас ухаалаг дэлгэцийг худалдан авахад 13.0 сая төгрөгийг шилжүүлж авлагад бүртгэсэн. 2022 онд ухаалаг самбарыг хүлээн авч данс бүртгэлд тусгаж, 0.6 сая төгрөгийн НДШ-ийн авлагыг суутган тооцож авлагыг барагдуулсан байна.
- 2022 оны эцэст 0.6 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь НДШ өр бөгөөд цалингийн программын кодын залруулгатай холбоотой үүссэн өр байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,707.2 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,717.2 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 299.1 сая төгрөгийн тогтмол зардал төлөвлөж 299.1 сая төгрөгийн тогтмол зардлын зарцуулалт гаргасан

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны улсын төсвийн батлагдсан төсвийг 425.2 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,415.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 296.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 1,717.2 сая төгрөгийг бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,401.0 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 296.6 сая төгрөг, нийт 1,707.9 сая төгрөг бүрдүүлж, нэмэлт санхүүжилтээр 10.0 сая төгрөг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,707.9 сая төгрөг 99.4 хувьтай байгаа бөгөөд дансны үлдэгдэл 9.5 сая төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол / байр ашиглалт 71802/80226	4,783.5	4,783.5	0.00	100%
2	Ерөнхий боловсрол /сургалт семинар 71802/80312	2,391.8	2,391.8	0.00	100%
3	Ерөнхий боловсрол /эрүүл мэндийг дэмжих 71802/81605	5,501.1	5,501.1	0.00	100
4	Ерөнхий боловсрол /үдийн цай 71802/81801	113,395.0	106,737.0	6,658.0	94%
5	Ерөнхий боловсрол / дотуур байрны хүүхдийн хоол 71802/81806	165.4	0	165.4	
6	Ерөнхий боловсрол /зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр 71802/81816	67,435.0	66,941.5	493.4	99.2%
7	Ерөнхий боловсрол /боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх 71802/81823	10,763.0	10,763.0	0.00	100%
8	Ерөнхий боловсрол /боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 71802/81834	1,213,299.9	1,213,299.9	0	100%
9	Ерөнхий боловсрол /сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 71802/81835	219,205.3	219,205.3	0	100%
10	Ерөнхий боловсрол /гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчныг сайжруулах 71802/81844	600.0	790.0	0.00	100%
11	Ерөнхий боловсрол /Сурах бичгийн түрээс 71802/81848	4,318.5	4,318.5	0.00	100%
12	Ерөнхий боловсрол /ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан 71802/83602	360.0	360.0	0.00	100%
13	Ерөнхий боловсрол /Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 71802/80111	244,156.8	244,156.8	0.00	100%
14	Ерөнхий боловсрол /Нийтлэг үйлчилгээ 71802/80112	52,459.5	52,459.5	0.00	100%
ДҮН		1,717,268.7	1,707,981.4	9,287.3	99.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Тогтвортой хөгжил 2 дэд төслийн санхүүжилт 10.0 сая төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 93 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБӨУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,055.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 20.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 78.7 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, ухаалаг самбар, өнгөт принтер, скайнер, суурин компьютерын худалдан авалт хийгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБӨУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 21 байна.

Нэмэлт дансаар 10.0 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэлд санхүүжилтийн мэдээллийг, зарлагын мөнгөн гүйлгээнд 19.7 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөж мэдээлүүлж залруулсан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах тухай зөвлөмж өгөгдсөнд тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой уг хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй тул зөвлөмжийн биелэлт хангагдсан гэж дүгнэхээр байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Төс	Дүн	Төс	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	140,500.0	1	140,500.0	100
Нийт дүн	1	140,500.0	1	140,500.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29.7 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 29.7 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

5.1 Залруулсан алдаа

Аудитаар шилэн дансны системд мэдээллийг дутуу байршуулсан 29.7 сая төгрөгийн алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэж заасны дагуу залруулав

Аудитаар нийт 6.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1.6 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 5.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

- Илүү цагаар ажилласан багш ажилчдын илүү цагийн нэмэгдлийг олгохдоо Засгийн газраас баталсан журмын хавсралт хүснэгтийн дагуу Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас бөглөөгүйгээс зарим багш ажилчид илүү цагаар ажилласан нь тогтоогдохгүй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна. Мөн журамд заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг зарим сард мөрдөн ажиллаагүйтэй холбоотой 1.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Гуравт "Нэмэгдэл хөлс олгох: 4. Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ. гэснийг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага бичив.

5.2 Зөвлөмж

1. Санхүүгийн анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөөд хүүхдүүд олны хүрээнд 11АЕВ, 9АЕВ ансийнхны тойрон аялал хийх хөтөлбөр баталж Мянган орд ХХК-нд 2.3 сая төгрөг, Увс аймгийн 1,2 дугаар сургуульд 44 багш туршлага судлах удирдамж гаргаж Ховд Бат Амар ХХК-руу 2.8 сая төгрөг бүгд 5.2 сая төгрөг шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны баримт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориолоно" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, зардлыг санхүүжүүлэхгүй байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Мэдээлэл дутуу мэдээлсэн	1	29,700.0	1	29,700.0	0	0	1	29,700.0				
Дүн	1	29,700.0	1	29,700.0	0	0	1	29,700.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан түвш	Тоо	Дүн

Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй	1	5,184.8				1	5,184.8	0	0	0	0
Илүү цагийн нэмэгдэл	1	1,605.4		1	1,605.4	0	0				
Дүн	2	6,790.2		1	1,605.4	1	5,184.8	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

[Signature]

17143692
073 9066454

Ц.АЗЗАЯА



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 2/11

Ховд

.../A2170425

ХОА-2022/121/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илүү цагаар ажилласан багш ажилчдын илүү цагийн нэмэгдлийг олгохдоо Засгийн газраас баталсан журмын хавсралт хүснэгтийн дагуу Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас бөглөөгүйгээс зарим багш ажилчид илүү цагаар ажилласан нь тогтоогдохгүй байна. Мөн журамд заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг зарим сард мөрдөн ажиллаагүйтэй холбоотой 1.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Гуравт "Нэмэгдэл хөлс олгох: 3. Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна.. 4. Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь: